



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

Ж.Золзаяаг ажилд түр томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 01/317 тоот албан бичгээр ирүүлсэн санал болон Авлигатай тэмцэх газрын 2023 оны “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай” 05/3288 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар Жаргалсайханы Золзаяаг 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн захирлаар түр томилсугай.

2. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын ажлыг Ж.Золзаяад хүлээлцэх ажлыг зохион байгуулж, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг 2023 оны 2 дугаар улиралд багтаан зохих журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх замаар нийтийн албан үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Жаргалсайханы Золзаяад даалгасугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

13-00107